



**МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/377

Ховд

**Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах, шинээр олгох, нэмэлт өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалт, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон “Өгөөмөр таван салаа”, “Маралжин” эмийн сан, Мөст сумын Эмийн эргэлтийн сан, “Танан шигтгээ” шүдний эмнэлэг, “Очир сүлд” мэдрэл нөхөн сэргээх эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр тус тус сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн эрх авахаар ирүүлсэн төсөл, хөтөлбөр нь дэмжигдэж, үйл ажиллагаа явуулах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын олонхийн санал авсан Манхан сумын “Тооройн элс” сувилал, Дарви сумын “Сутайн тун” эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай шинээр олгосугай.


3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах нөхцөл шаардлагыг ханган ажиллаж буй “Мөнхцохилохуй” зүрхний нарийн мэргэжлийн эмнэлэгт дүрс (зөөврийн рентген) оношилгооны, “Мөнгөн морьт” эмнэлэгт лабораторийн болон халдварт (дотрын) өвчнийг оношлох нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсугай.

4. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн “Баялаг тун”, “Хишиг тун” эмийн сан, “Мөнхийн тун” эмийн сангийн салбар эмийн сан, Дөргөн сумын “Төгий төсөл” элсний сувилал, “Элсэн Манхан”

8400 01 1942

сувиллуудын төслүүдийг дэмжиж, ажлын байрны дүгнэлт гаргуулж, шийдвэрлэхийг Эрүүл мэндийн газрын дарга (Ц.Мягмарсүрэн)-д даалгасугай.

5. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө сунгуулсан, нэмэлт өөрчлөлт оруулсан, шинээр олгосон байгууллагуудын үйл ажиллагаанд явцын хяналт тавьж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга (Ц.Мягмарсүрэн)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ